



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

┌ Хүндийн өргөлтийн Үндэсний шигшээ багийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам” Монголын хүндийн өргөлтийн холбооны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/19 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүндийн өргөлтийн Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсэнд өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 08 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын хүндийн өргөлтийн холбоонд үүрэг болгосугай.

3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын хүндийн өргөлтийн холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

6. Энэ тушаалтай гарсантай холбогдуулан Биеийн Тамир, Спортын Улсын Хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/29 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142410307

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ний
өдрийн А/НО дугаар тушаалын хавсралт

ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН
2024 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Спортын цол зэрэг	Албан тушаал
1	Цэнхэржав	Хосбаяр	МУГД	Дасгалжуулагч
2	Батжаргал	Дэнсмаа	ОУХМ	Дасгалжуулагч
3	Мөнхжанцан	Анхцэцэг	МУГТ	Тамирчин
4	Ганзориг	Ануужин	ОУХМ	Тамирчин
5	Энхбаатар	Энхтамир	ОУХМ	Тамирчин
6	Санлигринчен	Цэнгүм	ОУХМ	Тамирчин
7	Отгончимэг	Төгс-Эрдэнэ	ОУХМ	Тамирчин
8	Ариунболд	Ананд	ОУХМ	Тамирчин
9	Батнасан	Тунгалаг	ОУХМ	Тамирчин
10	Энхчимэг	Дүүрэнжаргал	ОУХМ	Тамирчин
11	Баярмагнай	Цолмон	ОУХМ	Тамирчин
12	Мөнхбаяр	Очир-Эрдэнэ	ОУХМ	Тамирчин
13	Муратбек	Бахберген	ОУХМ	Тамирчин
14	Сүхбат	Оюунбилэг	ОУХМ	Тамирчин
15	Алтангэрэл	Содгэрэл	ОУХМ	Тамирчин
16	Анхтуяа	Баясгалан	ОУХМ	Тамирчин

---oOo---